



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/48

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Татварын ерөнхий хуулийн 27<sup>1</sup> дугаар зүйлийн 27<sup>1</sup>.6.4, 38 дугаар зүйл, Засгийн газрын 2011 оны 344 дүгээр тогтоолоор батлагдсан "Татварын улсын байцаагчид үр дүнгийн шагнал олгох журам"-ын хоёрдугаар зүйлийн 2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Татварын улсын байцаагчийн ажил, үүргийн биелэлтийг дүгнэх журмыг 1 дүгээр хавсралтаар, ажил, үүргийн биелэлтийг дүгнэх хуудсыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Татварын улсын байцаагчийн ажил, үүргийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг үнэн зөв тооцон ажиллахыг Татвар ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн болон харьяа нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/83 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Алтансүх/-т үүрэг болгосугай.



ДАРГА

Л.ЗОРИГ

Татварын ерөнхий газрын даргын 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 1148 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



## ТАТВАРЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН АЖИЛ, ҮҮРГИЙН БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Татварын ерөнхий газар/цаашид ТЕГ гэх/-ын зохион байгуулалтын нэгжийн дарга, харьяа Улсын төсвийн орлого хяналтын газар, аймаг нийслэл, дүүргийн татварын албадын татварын улсын байцаагчийн ажил, үүргийн биелэлтийг дүгнэн, үр дүнгийн шагнал олгох харилцааг энэ журмаар зохицуулна.
- 1.2 Татварын улсын байцаагчийн ажил, үүргийн биелэлтийг дүгнэхдээ холбогдох хууль, тогтоомжийн дагуу, шударга, ил тод, бодитой үнэлэх зарчмыг баримтална.
- 1.3 Татварын улсын байцаагчийн үр дүнгийн шагналыг Татварын албанд ажиллаж байгаа татварын улсын байцаагчийн эрхтэй албан хаагчид олгох бөгөөд үр дүнгийн шагнал нь цалингийн бүрэлдэхүүн хэсэг байна.
- 1.4 Татварын улсын байцаагчийн үр дүнгийн шагналын эх үүсвэрийг ТЕГ-ын Санхүү хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь жил бүрийн төсөвт тусгаж, ТЕГ, түүний харьяа татварын нэгжид хуваарилан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
- 1.5 ТЕГ, түүний харьяа нэгжийн Татварын улсын байцаагчийн тухайн хугацааны үр дүнгийн шагнал олгох эсэх асуудлыг Татварын ерөнхий хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйлийн 27<sup>1</sup>.6.10-д заасны дагуу ТЕГ-ын дарга шийдвэрлэнэ.
- 1.6 Төрийн захиргааны асуудал хариуцсан нэгж нь татварын улсын байцаагчийн ажил, үүргийн биелэлтийн үнэлгээнд хяналт тавина.
- 1.7 Татварын улсын байцаагчийн сарын ажил, үүргийн биелэлтийг дүгнэсэн үзүүлэлт нь тухайн албан хаагчийн үр дүнгийн гэрээг дүгнэх үндэслэл болохгүй.

### Хоёр. Дүгнэх үзүүлэлт

- 2.1 Татварын улсын байцаагчийн сарын ажил, үүргийн биелэлтийг ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын байрны гол үйл ажиллагаа, үүрэг даалгаврын биелэлт, ажлын цаг ашиглалтын хувиудын дунджаар дүгнэнэ.
- 2.2 "Ажлын байрны гол үйл ажиллагаа, үүрэг даалгаврын биелэлт"-ийг тухайн татварын улсын байцаагчийн ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын байрны гол үйл ажиллагаа, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн хувиудын дунджаар дүгнэнэ. Дээрх хувийг авсан арга хэмжээ, хүрсэн үр дүнтэй уялдуулан дараах байдлаар тооцно.
  - Хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн авч, үр дүн гарсан бол 90-100 хувь,
  - Хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн авч, үр дүн гарч эхэлсэн бол 80-90 хувь,
  - Хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн авсан боловч үр дүн гараагүй бол 70-80 хувь
  - Хэрэгжүүлэх арга хэмжээг авч эхэлсэн бол 0-70 хувь
- 2.3 Тодорхой цаг хугацаанд хийгдэх үйл ажиллагаа, үүрэг даалгаврыг биелэлтийг тухайн хугацаанд нь оруулж дүгнэнэ.
- 2.4 Татварын улсын байцаагчийн ажлын байрны тодорхойлолтод заасан гол үйл ажиллагаа, үүрэг даалгавар нь холбогдох байгууллага, албан тушаалтны шийдвэрээр хэрэгжих боломжгүй болсон тохиолдолд үнэлгээнд оруулж дүгнэхгүй.



2.5 "Ажлын цаг ашиглалт"-ыг ажлын цагийн тодорхойлолтыг үндэслэн ажиллавал зохих хугацаанаас ээлжийн амралттай байсан хугацааг, ажилласан хугацаанаас өвчтэй, чөлөөтэй байсан, тасалсан хугацааг тус тус хасч бодит ажилласан хугацаагаар тооцно.

#### Гурав. Шагнал олгох хувь, хэмжээ

3.1 Татварын улсын байцаагчийн ажлын үнэлгээнд үндэслэн сарын үндсэн цалингаас үр дүнгийн шагнал тооцох хувийг дараах байдлаар тооцно. Ажил, үүргийн биелэлтийн дундаж хувь 2 шатлалд давхцсан тохиолдолд дээд шатлалд оруулна.

Ажил, үүргийн биелэлтийн дундаж хувь	Үр дүнгийн шагнал тооцох хувь
90-100 бол "А" буюу "Маш сайн";	30 хувь
80-90 бол "В" буюу "Сайн";	25 хувь
70-80 бол "С" буюу "Хангалттай";	15 хувь
60-70 бол "D" буюу "Дутагдалтай";	/ шагнал олгохгүй /
0-60 бол "F" буюу "Хангалтгүй".	/ шагнал олгохгүй /


#### Дөрөв. Ажил, үүргийн биелэлтийг тайлагнаж дүгнүүлэх

- 4.1 Сарын ажил, үүргийн биелэлтийг татварын улсын байцаагч шууд удирдах албан тушаалтанд, Улсын төсвийн орлого, хяналтын газар, аймаг, нийслэл татварын газар, хэлтсийн дарга ТЕГ-ын Төрийн захиргааны асуудал эрхэлсэн нэгжид, дүүргийн татварын хэлтсийн дарга Нийслэлийн татварын газарт дараа сарын 10-ны дотор, 12 дугаар сарын ажил, үүргийн биелэлтийг тухайн сарын 15-ны дотор багтаан тайлагнаж дүгнүүлнэ.
- 4.2 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил, үүргийн биелэлтээ хугацаанд нь тайлагнаагүй татварын улсын байцаагчид үр дүнгийн шагнал олгохгүй.
- 4.3 Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 344 дүгээр тогтоолын 3.1-д зааснаар сахилгын шийтгэл хүлээсэн Татварын улсын байцаагчид сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа хүртэл ажлын үр дүнгийн шагналыг олгохгүй.

#### Тав. Шагнал олгох хугацаа

- 5.1 Татварын улсын байцаагч нь үр дүнгийн шагналыг харьяалах татварын албаны даргын шийдвэрээр, Улсын төсвийн орлого, хяналтын газар, аймаг, нийслэлийн татварын албадын дарга нарын үр дүнгийн шагналыг ТЕГ-ын даргын шийдвэрээр, дүүргийн татварын хэлтсийн даргын үр дүнгийн шагналыг Нийслэлийн татварын газрын даргын шийдвэрээр олгоно.
- 5.2 Татварын улсын байцаагчийн сарын үр дүнгийн шагналыг дараа сарын, 12 дугаар сарын үр дүнгийн шагналыг тухайн сарын сүүлийн цалинтай хамт олгоно.

Татварын ерөнхий газрын даргын 2016 оны 12 дугаар сарын /4-ний өдрийн /4/ дугаар тушаалын 2 дугаар хавсралт



Татварын улсын байцаагчийн...оны... дүгээр сарын ажил, үүргийн биелэлтийг дүгнэсэн хуудас

Татварын алба:.....  
 Харьяалах нэгж:.....  
 Албан тушаал:.....  
 Овог нэр:.....

Огноо:.....

А. Татварын улсын байцаагчийн ажлын байрны тодорхойлолтод заасан гол үйл ажиллагаа, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар:				
№	Үйл ажиллагаа, үүрэг даалгаврын утга, агуулга	Биелэлт	Биелэлт /хувиар/	Дүгнэсэн /хувиар/
	1	2	3	4
1				
2				
3				
Үйл ажиллагаа, үүрэг даалгаврын биелэлтийн дундаж оноо				
Б. Ажлын цаг ашиглалт:				
	Ажиллабал зохих цаг	Ажилласан цаг	Цаг ашиглалт /хувиар/	Хянасан /хувиар/
<b>Нийт дундаж оноо</b>				

Дүгнэсэн: (гарын үсэг) / ..... / (нэр)

Тайлагнасан: (гарын үсэг) / ..... / (нэр)